



## Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.25 2019.03

### Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр Конгресс 2019 (CBID-AP) (2019.02.18)

2019 оны 7-р сарын 2,3-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо "Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр Конгресс 2019 : Asia-Pacific Community-based Inclusive Development Congress" зохион байгуулагдах гэж байна. Ерөнхий зохион байгуулагчаар Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам ажиллаж байгаа бөгөөд бэлтгэл ажилд JICA/DPUB төсөл хамтран ажиллаж байна. Тус конгресст голчлон Ази, Номхон далайн бүсийн орнуудаас нийт 600 орчим хүмүүс оролцох төлөвтэй байгаа ба Монгол Улсын засгийн газрын зүгээс хэрэгжүүлж буй Хөгжлийн бэрхшээлийн салбарын анхны томоохон олон улсын хурал юм. Монгол Улсын засгийн газар Улс, яамдууд, орон нутгийн засаг захиргаа гээд шат бүрт ХБИ-ийн оролцоотой Бодлогын зөвлөл байгуулан ажиллаж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлийн мэргэжлийн байгууллага болох "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар"-ыг байгуулан ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжин ажиллаж байна. Конгрессын үеэр Монгол Улсын эдгээр ахиц дэвшлийг бүс нутгийн орнуудад танилцуулан сурталчлахын зэрэгцээ бусад орнуудын сайн жишээнүүдээс суралцах замаар Ази, Номхон далайн бүс нутгууд бүхэлдээ ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжин ажиллах чиг шугамыг тодорхойлох болно. Та бүхэн ч гэсэн өргөнөөр оролцон, өөрсдийн үйл ажиллагааг танилцуулах боломжтой.

#### Конгрессын тухай мэдээлэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр Конгресс 2019 CBID

**Сэдэв :** Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагаар дамжуулан тогтвортой нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг дэмжих нь

**Хугацаа :** 2019 оны 7-р сарын 2~3 өдрүүд

**Байршил :** Улаанбаатар хот, Шангри-Ла зочид буудал

**Ерөнхий зохион байгуулагч :** Монгол Улсын Засгийн газар (Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам) • CBR Asia-Pacific Network

**Хамтран ажиллагч байгууллагууд :** WHO, UNESCAP, JICA/DPUB, Leonard Cheshire, CBM International, Italian Association Amici di Raoul Follereau (AIFO), and Asia-Pacific Development Center on Disability (APCD).

Дэлгэрэнгүй мэдээлэлтэй тус линкээр орж танилцана уу.

[www.apcbid2019.mn](http://www.apcbid2019.mn)

Илтгэгчдийг бүртгэх эцсийн хугацаа : 2019 оны 3-р сарын 30

Оролцогчдыг бүртгэх эцсийн хугацаа : 2019 оны 5-р сарын 31



Төслийн  
фэйсбүүк

хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **4278** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээлүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

JICA DPUB фэйсбүүк хуудсанд

**LIKE** дарж нэгдээрэй!!

<https://www.facebook.com/jicadpub/>

### Тайланд дахь сургалт ① (2019.03.07)



2-р сарын 13~21-ний өдрүүдэд Тайландын төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны талаар суралцах зорилгоор танилцах сургалт зохион байгууллаа. Уг сургалтанд төрийн албан хаагч 4 хүн, ТББ-аас 4 хүн хамрагдсан юм.



Тайландад 1983 онд Disability Thailand (DTH) гэдэг зөвлөл байгуулагджээ. Тус зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлтийг нэгтгэн нийт ТББ-уудыг төлөөлөн төр засагт дуу хоолойгоо хүргэдэг байна. Монголд ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд “нэгдэх” хэрэгтэй гэж ярьдаг ч ихэнх тохиолдолд ТББ-ууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тус тусдаа өөр өөрсдийн санал хүсэлтээ илэрхийлэх нь олон бөгөөд ТББ-уудын нэгдмэл байдал нь хараахан учир дутагдалтай байна. Иймээс Тайландад DTH зөвлөл анх хэрхэн бий болсон, мөн 35 гаруй жилийн хугацаанд төр засагтайгаа яаж хамтарч ажилласан, ямар үр дүнд хүрсэн талаар судлахаар Тайландыг зорьсон юм. Сургалтын үеэр хэд хэдэн лекц сонсож, Бангкок хотын хүртээмжтэй танилцан, оролцогчид өөр хоорондоо хэлэлцүүлэг өрнүүлсний эцэст олж мэдсэн хариултаудын нэг нь “нийтийн ашиг сонирхол (Common Interest)” байлаа.

Дэд бүтцийн хүртээмжтэй танилцав



Баруун гар талынх нь ноён Монтиан

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд хэрхэн нэгдмэл байдлыг бий болгож чадсан бэ ? Засгийн газрын зүгээс дэмжлэг тусалцаа байдаг уу ? Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн манлайлагч нь юугаараа шилдэг байх ёстой вэ ?

Маш олон хэлэлцүүлэг, асуултуудын эцэст хүрсэн хариултаудын нэг нь энэ байлаа. Олон төрлийн, олон янзын байгууллага, хувь хүмүүс нэгдэхийн тулд “харилцан ашиг”-тай байхгүй бол болохгүй. “Зөвхөн өөрийн эрх ашгийг нэн түрүүнд тавин, бусдын эрх ашгийг хүндэтгэхгүй тохиолдолд нэгдэл бий болох боломжгүй. Яаж “Нийтийн ашиг сонирхол”-ыг бий болгож чадах вэ гэдэг нь маш чухал”. Тайландын хөгжлийн бэрхшээлтэй 9 ТББ-уудын “нийтлэг ашиг сонирхол” гэж юу вэ ? Цаашид энэ асуултын хариултаг эрж хайх хэрэгцээ шаардлага тулгарч байна...

## Тайланд дахь сургалт ② (2019.03.11)



Танилцах сургалтын үеэр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудын “нэгдэл”-ээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлгөөн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогоос гарсан үр дүнгүүдтэй танилцлаа. Эдгээрээс хамгийн ихээр анхаарал татсан нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

хуульд заасан хөдөлмөр эрхлэлтийн хувь” байв. Тайландын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хуульд заасан хөдөлмөр эрхлэлтийн хувь нь 1% юм. Өөрөөр хэлбэл 100 ажилчинтай компани хамгийн багадаа хөгжлийн бэрхшээлтэй 1 хүнийг ажилд авах ёстой гэсэн үг. Энэ нь Монгол (4%) , Япон (2.3%)-той харьцуулахад бага хувь. Нөгөөтэйгүүр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй тохиолдолд төлбөрийг “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ Х 365 хоног” –оор бодож тооцдог бөгөөд квот хангаагүй аж ахуй нэгжүүд жил бүр Засгийн газарт төлөх ёстой байдаг. Үүнийг Японтой харьцуулж үзвэл маш өндөр төлбөр ба хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 1 хүнийг ажиллуулсан нь хямд тусах учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж байна. 2012 оны зааг дээр Тайландын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд томоохон ахиц гарсан гэдгийг Redemptorist МСҮТ-ийн холбогдох хүмүүс ч ярьж байлаа. Тэгвэл нөхөн төлбөрийг яаж ийм “өндөр дүн”-тэй болгож чадсан юм бол оо? Үүний нууц нь DTH (Тайландын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл)-ийн нэгдмэл байдал болон хэлэлцээр хийх чадварт байлаа. DTH нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлтийг нэгтгэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогын зөвлөлд хандан хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг сайжруулахыг шаардаж байсан ба үүний хэрэгжүүлэхэд “Өндөр дүнтэй нөхөн төлбөр”-ийн тогтолцоо шаардлагатай гэдэг санал дэвшүүлэн Засгийн газраар зөвшөөрүүлж чаджээ. Энэ хэлэлцээрийг хийхэд нэлээд хэдэн жилийн хугацаа шаардагдсан бөгөөд үүний үр дүнд Тайландын өвөрмөц онцлог бүхий Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бий болжээ. Тус лекцийг сонссоноор Тайландын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ууд аль хэдийн бие дааж, өөрсдөө бодлого боловсруулах, санал дэвшүүлэх, хэлэлцээр хийх чадвартай болсон байгааг ойлголоо. Гадаадын тусламжаар биш өөрсдийн гэсэн үзэл бодол, зорилготойгоор үйл ажиллагаа явуулж буй DTH зөвлөл нь Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудад томоохон жишээ болсон байх аа. Монголд ч гэсэн DTH зөвлөлтэй эн зэрэгцэх байгууллагыг бий болгох шаардлагатай эсэх тал дээр оролцогчид хэлэлцүүлэг өрнүүлээ.

## Хөгжлийн бэрхшээлийн тухай 3 дахь удаагийн цуврал хичээл (2019.01.24)



Манлайлагч 5 залуустай хамт ~

Оролцогчдоос өндөр үнэлгээ авсан Хөгжлийн бэрхшээлийн тухай 3 дахь цуврал хичээл амжилттай эхэллээ. Энэ удаагийн хичээлд 50 гаруй хүн хамрагдсан бөгөөд олон шинэ оролцогчид нэмэгдсэн байсан нь баярлуштай явдал байв. Энэ удаа Японд суралцаад ирсэн хөгжлийн бэрхшээлтэй 5 манлайлагч залуус яриа хийлээ. Эдгээр залуусын 1 нь ЖАЙКА-ийн Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх сургалт, 4 нь Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчдыг бэлтгэх Даскин



хөтөлбөрийн оролцогчид юм. Тэд эх орондоо ирснийхээ дараа ч амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Н.Цогтсайхан IT компанийн захирлаар, Ч.Ундрахбаяр Бие даан амьдрах төвийн тэргүүнээр ажиллаж байгаа юм.



Япон улс эдийн засгийн өндөр хөгжилтэй учраас хөгжлийн бэрхшээлийн нийгмийн халамж сайн байх нь мэдээжийн хэрэг хэмээн сургалтанд оролцохоосоо өмнө бодож байсан ч яг бодит нөхцөл байдал дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө төр засагтайгаа хэлэлцээр хийн бодлогыг

өөрчилж ирсэн байдаг. Тийм учраас бид нар ч бас өөрсдөөсөө эхлэх хэрэгтэй гэж оролцогчдыг уриалж байсан нь сэтгэгдэл төрүүллээ.

Дээрх яриаг сонсоод оролцогчдын олонх нь Японы сургалтанд хамрагдах хүсэлтэйгээ илэрхийлж байсан бөгөөд хэрхэн хамрагдах талаар асууж байв.

### Шинэ сорилт



Ахлах зөвлөх Чибэ Хисао

Шинээр нээгдэх төвд мэргэжилтнээр ажилд орё гэж хариулсан боловч хэзээ, хаана, ямар ажил хийх талаар огт ойлголтгүй байв. Хэдийгээр Кавамура багш тодорхойлолт гаргаж өгсөн боловч ЖАЙКА албан ёсоор ажилд авах эсэхийг ч мэдэхгүй байлаа. Гэтэл ажил хэрэг бодсоноос ч илүү хурдацтай урагшилж, нэг мэдэхэд 2002 оны 7-р сараас ЖАЙКА-ийн мэргэжилтнээр томилогдон ажиллахаар болов. Ингээд ESCAP-т ажлаас гарах өргөдлөө өгч, байр сууцаа цэгцлэн нутаг буцах бэлтгэлээ хангаж эхэлсэн юм. Учир нь ЖАЙКА-ийн мэргэжилтнээр томилогдох хүмүүс заавал Японд сургалтанд хамрагдах ёстой байдаг. ESCAP-ыг орхин явах нь надад харамсалтай байсан ч шинэ сорилтод хүч үзэхээр сэтгэл шулуудсан байв. Энэ бүхэн Олон улсын хамтын ажиллагааны салбарт ажиллахыг зорилт болгосноос хойш 6 жилийн дараа болсон үйл явдал. Япон компанид техникийн ажилтан байсан би эцэст нь ингэж нэг Олон улсын хамтын ажиллагааны салбарт мэргэжилтнээр ажиллах боллоо. Хамгийн харамсалтай нь мэргэжилтнээр ажиллахаар болсон жилийн 6-р сард ээж минь нас нөгчсөн явдал байв. Эрх дураараа зантай намайг чанга гараар өсгөсөн ээж минь хүүгээ мэргэжилтэн болмогц тэнгэрт одсон нь үнэхээр харамсалтай байсан ч өнөөг хүртэл ажлаа үргэлжлүүлж ирсэн маань намайг өсгөж хүмүүжүүлсэн ээжийн минь ач юм даа гэж талархаж явдаг. (Үргэлжлэл бий...)

### DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)